

**МОНГОЛ АРДЫН НАМААС 2020 ОНЫ
ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
“ХҮНИЙ ХӨГЖИЛ–ЖАРГАЛАНТЫН
ХӨГЖИЛ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

2020 ОН



ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭД, СОНГОГЧИД ОО

Жаргалант сумын Монгол Ардын намаас 2020 оны орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд Жаргалант сумын иргэд Та бүхнийхээ сайн сайхан амьдрал, сумын нийгэм эдийн засаг, экологийн тогтвортой хөгжлийг хангах асуудлыг баттай бүрдүүлэх зорилгоор иргэдээс ирсэн санал хүсэлт, удаа дараагийн судалгааны дүн, 2016-2020 онд хэрэгжүүлсэн бодит ажил, хүрсэн үр дүнд үндэслэн боловсруулсан “**ХҮНИЙ ХӨГЖИЛ–ЖАРГАЛАНТЫН ХӨГЖИЛ**” хөтөлбөрөө танилцуулж байна.

Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхийг урьж байна.

Мөрийн хөтөлбөр нь долоон үндсэн зорилттой

Үүнд:

1. Эрүүл мэнд, чийрэгжүүлэлтийн үйлчилгээ
2. Нийгмийн халамжийн үйлчилгээ
3. Боловсрол, соёлын үйлчилгээ
4. Эрүүл хүнс, цэвэр орчин, ногоон хөгжил
5. Дэд бүтцийн хангамжийг сайжруулах асуудал
6. Үйлдвэрлэл, үйлчилгээний талаар
7. Засаглалыг хөгжүүлэх асуудал

Иргэн Таны болон төрөлх Жаргалант сумын хүсэл тэмүүлэл, хөгжил дэвшлийн зангилаа асуудлыг шүүн тунгааж боловсруулсан хөтөлбөртэй тав тухтай танилцаж хамтран ажиллана гэдэгт итгэл төгс байна.

ЖАРГАЛАНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМ

A red rectangular stamp is located in the bottom right corner of the page. To its right is a handwritten signature in black ink.

МОНГОЛ АРДЫН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ХҮНИЙ ХӨГЖИЛ –ЖАРГАЛАНТЫН ХӨГЖИЛ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ЗОРИЛТ НЭГ: ЭРҮҮЛ МЭНД, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Эрүүл Жаргалантчууд дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- Спорт зааланд нэмэлт техник, тоног төхөөрөмж, эд хогшлоор хангах, секц дугуйлан хичээллүүлэх
- Сумын урлаг, спортын бага наадмыг улирал бүр зохион байгуулж дэмжлэг болгон ажиллах
- Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг тоног төхөөрөмж, эд хогшлоор хангах, хуучин байрны их засвар хийх, автомашины граж барих, гаднах тохижилтын асуудлыг шийдвэрлэх
- Халдварт бус өвчний эрт илрүүлгийг үе шаттайгаар хийх
- Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж байгууллага, аж ахуйн нэгж, багуудын оролцоог сайжруулан үүрэг хариуцлага үр дүнг тооцох
- Хойд хороолол урд хорооллыг холбосон эрүүл мэндийн замтай болох
- Ахмад залуучуудын ордонг түшиглэн фитнес, бильярд, тениссны клуб бий болгох

ЗОРИЛТ ХОЁР: НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Залуу гэр бүл болон бага дунд орлоготой айл өрхийг орон сууцаар хангахад өөрчлөлт гаргана. Энэ асуудлыг Эрдэнэт төрийн өмчийн үйлдвэрийн хамтын ажиллагааны нэг чиглэл болгож ажиллана.
- Ахмад настнаа дэмжих "Ач санах" дэд хөтөлбөр, Эрдэнэтийн анхдагч, илгээлтийн эздэд "Анхдагч" дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн шаардлагатай ажил, арга хэмжээг үргэлжлүүлэхийн хамт шинэ агуулгаар баяжуулж ажиллана.
- Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан зэрэг зорилтод бүлэг рүү чиглэсэн нийгмийн халамж, хамгааллын бодлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах ажлыг цахим хэлбэрээр нийтэд нээлттэй зохион байгуулна.
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрхийн амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой иргэдэд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

- Ахмад залуучуудын ордонг барьж дуусгах, шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшлоор хангах
- “Жаргалантын залуучууд” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- “Жаргалантын ногоочид” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- “Малжуулах” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- Ногоочдын талбайн хашаажуулалтыг бүрэн хийж дуусгах
- Нийтийг хамарсан ажилд ажилгүй иргэдийг хамруулж түр ажлын байраар хангах
- Залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх

ЗОРИЛТ ГУРАВ: БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

- Ардын уламжлалт зан үйл, ёс зүй, зан заншил, зөв амьдрах ухаан хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд монголчуудын оруулсан хувь нэмэр, байгальтайгаа хүйн холбоотой амьдарч ирсэн Монголчуудын өв уламжлал, харилцааны ёс зүй, суурь үнэт зүйлсийг цэцэрлэг, Ерөний боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулж хэрэгжүүлнэ.
- Цэцэрлэгийн өргөтгөл барих
- Цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, засварын асуудлыг шийдвэрлэх
- Сургуулийн их засвар, тоног төхөөрөмж эд хогшлоор хангах
- Ардын уламжлалт гар урлал, амьдрах ухааны чиглэлээр шавь сургалтыг дэмжинэ.
- 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Багш” дэд хөтөлбөрт заасан чухал шаардлагатай арга хэмжээг 2020-2024 онд шинэ агуулгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Суманд хэрэгжүүлж эхэлсэн “Боловсрол” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- “Гэр бүл-Үндэсний соёл, зан заншил” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Цэцэрлэгийн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, стандартын шаардлагад нийцүүлэн тоглоом наадгай, эд хогшлоор хангах
- Соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, Үндэсний хөгжмөөр иргэдийг хичээллэх төрөл бүрийн дугуйлан явуулахад дэмжлэг болгон хөтөлбөр хэрэгжүүлэх


ЗОРИЛТ ДӨРӨВ: ЭРҮҮЛ ХҮНС, ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

- Жаргалант сумын хил залгаа аймгуудын нутаг дэвсгэрт өрхийн тариалалтыг дэмжих, хамтарч ажиллах төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.
- Уламжлалт нүүдлийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажлыг өргөжүүлж хоршоо, фермерүүдийг дэмжинэ.

- Үүлдэр омог гойд ашиг шимт малыг өсгөн үржүүлнэ.
- Мал амьтны ус хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлж, өвөлжөө хаваржааны бэлчээрийг худаг уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд оновчтой хэлбэрээр эзэмшүүлнэ.
- Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний стандарт, хүртээмж, материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.
- Өндөр ургац өгдөг сортын үр тариа, тэжээлийн ургамлын болон жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлнэ.
- Хүлэмжийн аж ахуй байгуулах, нарийн ногоо тарих хөдөлгөөн өрнүүлж, өвлийн хүлэмж байгуулах иргэд, аж ахуй нэгж, байгууллагын санал санаачлагыг дэмжин хамтран ажиллана.
- Хөрсний бохирдлыг бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг дэмжиж урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгон төр, хувийн хэвшлийн бүх байгууллагад ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ.
- Голын гольдрол, гуу жалга, далангийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үерийн далангийн байгууламжийг нэмэгдүүлэн гадаргын усны бохирдлыг бууруулна.
- Ойн нөөцийг хамгаалах нөхөн сэргээх, ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад ой модны зохистой ашиглалт, тогтвортой менежментийг бий болгож, ойн санг нэмэгдүүлэн, модны хэрэглээг бууруулна.

ЗОРИЛТ ТАВ: ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ АСУУДАЛ

- Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай 100 айлын орон сууц барих
- Сумын цэвэрлэх байгууламжийг засварлах
- Сумын инженерийн шугам сүлжээг тодорхой үе шаттай шинэчлэн сайжруулна.
- Жаргалант багийн айл өрх, ААН-ийг хэрэглээний халуун усанд холбох
- Гэр хорооллын бүх багт “Миний гудамж-Бидний гэр” төслийг хэрэгжүүлж зам талбай, гэрэлтүүлэг, камержуулалтыг дэс дараатайгаар шийдвэрлэнэ.
- Сумын тохижилт, хог хаягдлын асуудлыг орчин үеийн хотын хөгжилд нийцүүлэн шийдвэрлэж, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- Найрамдал хороололд гүний худаг барих
- Жаргалант багийн Булагын баруун болон зүүн талаар явган хүний зам тавих
- Улаантолгой багийн гудамж хороонд сайжруулсан замыг үргэлжлүүлэн барих
- Дулаан-Уул багт шинээр худаг гаргах, засварлах



- Жаргалант баг болон Улаантолгой багийн малыг хариулгатай болгох Дулаан-Уул багийн зарим газрыг чөлөөлж бэлчээрийн газар гаргах
- Орон сууцнуудын бохирын шугамуудыг засварлах
- Орон сууцнуудын цахилгаан монтажийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх
- Дулаан-Уул багийн малчдыг ногоон тэжээл тарих боломжийг бүрдүүлж дэмжиж ажиллах
- Эко ариун цэврийн байгууламжийг үргэлжлүүлэн хийх
- Хойд хорооллыг ухаалаг худагтай болгох
- 136-р тоочикт гүүр барих
- Бөөн бургасанд Хангал голын дагуу гүүр барих
- Урд хорооллын замыг сумын төвтэй холбосон явган хүний болон дугуйн замтай болгох
- Хадлангийн талбай хашаажуулах
- Тасаг болон төмөр замыг холбосон замыг засварлах
- Тасагт тоглоомын талбай болон камержуулалт, гэрэлтүүлэг хийх
- Бранк байрны цахилгаан монтаж шинэчлэх
- Соёл мэдээллийн төв, спорт заал, ЕБС-ийн хоорондох бохирын шугамыг засварлах
- Сумын Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшлоор хангах

ЗОРИЛТ ЗУРГАА: ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

- “Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ”-г түшиглэн шахмал түлшний үйлдвэр барина.
- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, ажлын байрны тоог нэмэгдүүлэн өрхийн бодит орлогыг өсгөнө.
- “Эрдэнэт” шинжлэх ухаан технологийн паркийн дэргэдэх бизнес инкубацийн үр ашгийг сайжруулж, бойжигчдын тоог нэмэгдүүлж жижиг дунд бизнес эрхлэгчдийн хүрээг өргөжүүлнэ .
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах ажилд орон нутгийн аж ахуй нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжиж хамтран ажиллана.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулж иргэдэд ил тод болгоно.
- Хил залгаа бүс нутаг, орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлох үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд технологийг нэвтрүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангах бодлого барина.



ЗОРИЛТ ДОЛОО: ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР

- “Жаргалант-2030” хөтөлбөр боловсруулж хөгжлийн 10 жилийн цогц бодлого хэрэгжүүлнэ.
- Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн үйл ажиллагаа, ёс зүйд хяналт тавьж хууль зөрчсөн, алдаа гаргасан тохиолдолд хариуцлага хүлээдэг хандлагыг төлөвшүүлнэ.
- Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахимаар хянадаг болно.
- “Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөр хэрэгжүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулна.
- Төрийн албан хаагчдын хувийн болон хамтын манлайллыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн хамт багуудын өөр хоорондоо хамтарч ажиллах, ялгарч хөгжих санал санаачлагыг өрнүүлнэ.
- Төрийн бүх шатны байгууллагуудын дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг сайжруулахын хамт төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэд хэрхэн үнэлж байгааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийн дагуу судалж ил тод мэдээлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.
- Хил залгаа Булган, Сэлэнгэ аймаг, тэдгээрийн сумдтай хамтын ажиллагааг өргөжүүлж, тулгамдаж буй асуудлуудыг хамтран шийдвэрлэнэ.
- Сумын иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг хангах үндсэн үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, техник тоног төхөөрөмжийн хангамж, үйл ажиллагааны чанарыг сайжруулж гэмт хэргийн гаралтыг бууруулна.



ЖАРГАЛАНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

